

АЛДАГДСАН БУЮУ ГЭМТТЭЭГДСЭН НОМ ХЭВЛЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. Номын сангаас уншигчдад үйлчлэх явцад алдагдсан буюу гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь ном хэвлэл /үнэт ховхр, ганц хувь, гар бичмэл, ном судар—ийг гэмтээх, алдаж үрэгдүүлэхээс хамгаалж сэргийлэхэд оршино.
- 1.3. Энэхүү журмыг ном хэвлэлтэй харьцаж буй номын сангийн байгууллага бүр дагаж мөрдөнө.

Хоёр. Номын санчид хүлээлгэх хариуцлага:

Дор дурдсан тохиолдолд номын санчид хариуцлага хүлээлгэнэ

- 2.1. Номын санч нь уншигчдад ном хэвлэл олгох, буцааж авхадаа шалгаагүйгээс түүний хуудас урагдсан, гэмтсэн, хуудас алга болсон тохиолдолд тухайн хэвлэлийг бүрэн бүтэн болгох
- 2.2. Хэрэв 3 - аас дээш хувьтай ном алдаж үрэгдүүлсэн тохиолдолд уг номын үнийг тухайн үеийн үнийн ханшаар буюу нөхөн бүрдүүлэх шаардлагатай номоор төлүүлэх.
- 2.3. 3-аас доош хувьтай ном хэвлэл алдсан буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд номыг номоор нь буюу номын санд нөхөн бүрдүүлэх шаардлагатай номоор төлүүлэх.
- 2.4. Номын сангийн журам зөрчин гэрээр болон уншлаганд гаргадаггүй ном хэвлэл / гар бичмэл, ганц хувь ном, барын ном, толь бичиг, нэвтэрхий толь, гэх мэт/-ийг алдаж үрэгдүүлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 132 дугаар зүйлийн 1, 136 дугаар зүйлийн 3-д заасны дагуу арга хэмжээ авна.

Гурав. Уншигчдад хүлээлгэх хариуцлага:

- 3.1. Уншигч нь номын сангийн дүрэм, журам, зөрчин уншлагын танхимд уншихаар авсан ном, хэвлэлээ эргүүлж өгөлгүй авч гарсан тохиолдолд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ.

а. / Харъяалагдах байгууллага, сургуулийн захиргаанд мэдэгдэх.

б. / Номын сангаас авч гарсан ном хэвлэлийг эргүүлэн авч, уншигчийн үнэмлэхийг нь 3-6 сарын хугацаагаар хураах.

в. / Хэрэв авч гарсан ном хэвлэлээ алдаж үрэгдүүлсэн тохиолдолд номыг номоор нь буюу тухайн үеийн үнийн ханшаар нь төлүүлэх.

3.2. Уншихаар авсан ном хэвлэлээс хуудас дутаасан, өнгө үзэмжийг нь бууруулсан мэдээллийг нь алдагдуулсан тохиолдолд уг хуудсыг ижил номноос нь хувилуулан бүрэн болгох.

Дөрөв. Нийтлэг хариуцлага:

4.1. Алдагдсан ба гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэхэдээ энэхүү журмын 2,3-р зүйлийн заалтууд болон хөдөлмөрийн хуулийн 136 дугаар зүйлийн 2-д заасны дагуу төлүүлнэ.

4.2. Уншигч буюу номын санч нь номын сангийн захиргаанаас тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй бол шүүхэд шилжүүлнэ.